



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/18/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: [bayanjargalg@audit.gov.mn](mailto:bayanjargalg@audit.gov.mn)

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт .....	3
<b>2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....</b>	<b>5</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
<b>3. Аудитын тайлан .....</b>	<b>11</b>
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
<b>4. Аудитын илрүүлэлт .....</b>	<b>19</b>
4.1 Залруулсан алдаа .....	19
4.2 Төлбөрийн акт .....	20
4.3 Албан шаардлага .....	20
4.4 Зөвлөмж .....	22

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
НХМ	Нэг хэвийн маягт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТЗ, ТҮ	Төрийн захиргаа, Төрийн үйлчилгээ
АГА	Ажил гүйлгээний анги
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, Иймэл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/66  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА З.АМГАЛАН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ  
19020259

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>98,854,244.52</b>	<b>102,589,504.91</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	98,854,244.52	102,589,504.91
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	756,800.00	493,130.00
35130	Эм боох материал	756,800.00	493,130.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	98,097,444.52	102,096,374.91
35410	Бичиг хэргийн материал	11,529,491.32	13,051,880.21
35420	Аж ахуйн материал	80,046,217.64	83,141,579.64
35440	Түлш, шатах тослох материал	2,389,960.06	2,207,715.06
35450	Барилгын засварын материал	265,500.00	23,500.00
35470	Бусад хангамжийн материал	3,866,275.50	3,671,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>590,161,583.62</b>	<b>532,616,569.89</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	590,161,583.62	532,616,569.89
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	574,261,583.62	516,716,569.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	275,441,881.76	280,441,881.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	11,754,816.64	20,265,483.09
39203	Авто-тээврийн хэрэгсэл	165,000,000.00	165,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	58,181,269.20	69,992,330.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	287,948,491.67	334,438,891.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	96,706,745.91	195,909,812.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,171,078.64	60,170,626.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	37,082,258.35	39,256,553.74
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,250,000.00	20,250,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	17,171,595.35	19,507,467.35
39217	Ном	1,346,817.00	1,346,817.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	15,900,000.00	15,900,000.00
39301	Програм хангамж	830,550.00	830,550.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	830,550.00	830,550.00
39303	Бусад биет бус хөрөнгө	15,900,000.00	15,900,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>689,015,828.14</b>	<b>635,206,074.80</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>689,015,828.14</b>	<b>635,206,074.80</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	689,015,828.14	635,206,074.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	346,465,028.90	346,465,028.90
51101	Өмч: - төрийн	346,465,028.90	346,465,028.90
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	289,348,278.36	235,538,525.02
51210	Өмнөх үеийн үр дүн	(193,835,369.75)	289,348,278.36
51220	Тайлант үеийн үр дүн	483,183,648.11	(53,809,753.34)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	53,202,520.88	53,202,520.88
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>689,015,828.14</b>	<b>635,206,074.80</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,373,617,086.81</b>	<b>1,079,645,658.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>498,572,084.81</b>	<b>80,065,258.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	498,572,084.81	80,065,258.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	498,572,084.81	80,065,258.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	232,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	498,340,084.81	80,065,258.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>875,045,002.00</b>	<b>999,580,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	875,045,002.00	999,580,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	875,045,002.00	999,580,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>890,433,438.70</b>	<b>1,133,455,411.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>890,433,438.70</b>	<b>1,133,455,411.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	845,311,853.50	973,146,396.12
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	625,560,741.35	622,574,515.60
210101	Үндсэн цалин	434,194,705.86	392,133,594.69
210102	Нэмэгдэл	115,213,186.91	114,991,797.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,738,058.84	58,476,628.92
210104	Урамшуулал	42,414,789.74	56,972,494.56
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	82,363,418.21	80,389,254.91
210201	Тэтгэврийн даатгал	57,545,036.35	55,941,674.31
210202	Тэтгэмжийн даатгал	6,228,592.50	6,217,181.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,969,434.05	4,945,794.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,238,286.82	1,207,154.31
210205	Эрүүл мэндийн даатгал	12,382,068.49	12,077,451.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,033,162.00	42,254,024.00
210301	Гэрэл, цахилгаан	3,606,960.00	4,164,962.00
210302	Түлш, халаалт	35,793,802.00	35,775,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,632,400.00	2,313,362.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,053,327.32	37,502,637.90
210401	Бичиг хэрэг	6,745,487.08	11,563,298.09
210402	Тээвэр, шатахуун	5,433,040.00	4,538,245.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,499,880.24	4,293,610.29
210404	Ном, хэвлэл	237,540.00	33,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330,000.00	251,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	807,380.00	16,823,184.52
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,301,200.00	422,800.00
210604	Урсгал засвар	1,301,200.00	422,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,172,500.00	4,220,000.00
210702	Дотоод албан томилолт	4,172,500.00	4,220,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	35,870,515.00	58,038,201.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,910,000.00	52,943,686.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	283,815.00	158,895.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,000.00	175,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,150,000.00
210807	Газрын төлбөр	47,700.00	47,700.00

Төв аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	33,956,989.62	127,744,961.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	620,400.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,363,730.00	3,710,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,972,859.62	124,034,961.73
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	45,121,585.20	160,309,015.22
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	33,115,477.00	84,014,918.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,115,477.00	82,334,918.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,680,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	11,774,108.20	76,294,097.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,774,108.20	76,294,097.22
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	232,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	232,000.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>483,183,648.11</b>	<b>(53,809,753.34)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>483,183,648.11</b>	<b>(53,809,753.34)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>875,277,002.00</b>	<b>999,580,400.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>875,277,002.00</b>	<b>999,580,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	875,277,002.00	999,580,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	875,045,002.00	999,580,400.00
131003	Туслах үйл ажилгааны орлогоос	232,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>866,478,002.00</b>	<b>999,580,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>866,478,002.00</b>	<b>999,580,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>821,356,416.80</b>	<b>839,271,384.78</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	625,560,741.35	622,574,515.60
210101	Үндсэн цалин	434,194,705.86	390,467,131.69
210102	Нэмэгдэл	115,213,186.91	116,658,261.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,738,055.84	58,476,628.92
210104	Урамшуулал	42,414,792.74	56,972,493.88
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	82,363,418.21	80,389,254.91
210201	Тэтгэврийн даатгал	57,545,036.35	55,941,674.31
210202	Тэтгэмжийн даатгал	6,228,592.50	6,217,181.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,969,434.05	4,945,794.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,238,286.82	1,207,154.31
210205	Эрүүл мэндийн даатгал	12,382,068.49	12,077,451.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,033,162.00	42,254,024.00
210301	Гэрэл, цахилгаан	3,606,960.00	4,164,962.00
210302	Түлш, халаалт	35,793,802.00	35,775,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,632,400.00	2,313,362.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,701,080.24	23,118,388.29
210401	Бичиг хэрэг	3,579,900.00	6,560,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,833,000.00	4,356,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,161,950.24	4,495,130.29
210404	Ном, хэвлэл	447,600.00	214,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330,000.00	751,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,348,630.00	6,742,258.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,640,000.00	1,798,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	998,000.00
210604	Урсгал засвар	1,640,000.00	800,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,172,500.00	4,220,000.00
210702	Дотоод албан томилолт	4,172,500.00	4,220,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	37,080,515.00	59,597,201.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,120,000.00	53,952,686.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	158,895.00	158,895.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,920.00	175,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,700,000.00
210807	Газрын төлбөр	47,700.00	47,700.00

Төв аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,805,000.00	5,320,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	161,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,644,000.00	5,320,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>45,121,585.20</b>	<b>160,309,015.22</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	33,115,477.00	84,014,918.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,115,477.00	82,334,918.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,680,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	11,774,108.20	76,294,097.22
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	232,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	232,000.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>8,799,000.00</b>	<b>-</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		-
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,799,000.00</b>	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,799,000.00</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	8,799,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,799,000.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(8,799,000.00)</b>	<b>-</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(0.00)	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	-193,835,369.75		205,832,180.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	-193,835,369.75	0.00	205,832,180.03
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			483,183,648.11		483,183,648.11
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	289,348,278.36	0.00	689,015,828.14
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	289,348,278.36	0.00	689,015,828.14
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	289,348,278.36	0.00	689,015,828.14
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-53,809,753.34		-53,809,753.34
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	235,538,525.02	0.00	635,206,074.80

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>875,045,100.00</b>	<b>863,270,893.80</b>	<b>999,580,400.00</b>	<b>923,286,302.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>875,045,100.00</b>	<b>863,270,893.80</b>	<b>999,580,400.00</b>	<b>923,286,302.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>841,929,500.00</b>	<b>830,155,416.80</b>	<b>915,565,400.00</b>	<b>839,271,384.78</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>630,894,000.00</b>	<b>625,560,741.35</b>	<b>683,053,000.00</b>	<b>622,574,515.60</b>
210101	Үндсэн цалин	404,107,600.00	434,194,705.86	387,633,700.00	390,467,131.69
210102	Нэмэгдэл	139,169,800.00	115,213,186.91	143,347,200.00	116,658,261.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,800,000.00	33,738,055.84	62,436,000.00	58,476,628.92
210104	Урамшуулал	67,816,600.00	42,414,792.74	89,636,100.00	56,972,493.88
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>85,670,700.00</b>	<b>82,363,418.21</b>	<b>92,114,200.00</b>	<b>80,389,254.91</b>
210201	Тэтгэврийн даатгал	58,048,200.00	57,545,036.35	64,792,100.00	55,941,674.31
210202	Тэтгэмжийн даатгал	6,905,600.00	6,228,592.50	6,830,500.00	6,217,181.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,524,500.00	4,969,434.05	5,464,400.00	4,945,794.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,381,100.00	1,238,286.82	1,366,100.00	1,207,154.31
210205	Эрүүл мэндийн даатгал	13,811,300.00	12,382,068.49	13,661,100.00	12,077,451.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,517,600.00</b>	<b>41,033,162.00</b>	<b>43,388,700.00</b>	<b>42,254,024.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,839,600.00	3,606,960.00	4,484,700.00	4,164,962.00
210302	Түлш, халаалт	37,603,000.00	35,793,802.00	35,775,700.00	35,775,700.00
210303	Цэвэр, бохир ус	2,075,000.00	1,632,400.00	3,128,300.00	2,313,362.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,013,700.00</b>	<b>21,701,080.24</b>	<b>25,733,700.00</b>	<b>23,118,388.29</b>
210401	Бичиг хэрэг	3,579,900.00	3,579,900.00	6,560,000.00	6,560,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,833,000.00	4,833,000.00	4,356,000.00	4,356,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,163,700.00	6,161,950.24	6,853,800.00	4,495,130.29
210404	Ном, хэвлэл	447,600.00	447,600.00	433,400.00	214,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	665,500.00	330,000.00	780,500.00	751,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,324,000.00	6,348,630.00	6,750,000.00	6,742,258.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,640,000.00</b>	<b>1,640,000.00</b>	<b>1,800,000.00</b>	<b>1,798,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл			1,000,000.00	998,000.00
210604	Урсгал засвар	1,640,000.00	1,640,000.00	800,000.00	800,000.00
<b>2107</b>	<b>Томилгоот, зочны зардал</b>	<b>4,172,500.00</b>	<b>4,172,500.00</b>	<b>4,220,000.00</b>	<b>4,220,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,172,500.00	4,172,500.00	4,220,000.00	4,220,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,417,000.00</b>	<b>37,080,515.00</b>	<b>59,935,800.00</b>	<b>59,597,201.98</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,206,000.00	36,120,000.00	53,975,200.00	53,952,686.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00	540,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	345,900.00	158,895.00	158,900.00	158,895.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,000.00	191,920.00	192,000.00	175,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	255,400.00	22,000.00	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ			5,000,000.00	4,700,000.00
210807	Газрын төлбөр	47,700.00	47,700.00	47,700.00	47,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,604,000.00</b>	<b>16,604,000.00</b>	<b>5,320,000.00</b>	<b>5,320,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,960,000.00	8,960,000.00		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,644,000.00	7,644,000.00	5,320,000.00	5,320,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,115,600.00</b>	<b>33,115,477.00</b>	<b>84,015,000.00</b>	<b>84,014,918.00</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг				
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>33,115,600.00</b>	<b>33,115,477.00</b>	<b>84,015,000.00</b>	<b>84,014,918.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,115,600.00	33,115,477.00	82,335,000.00	82,334,918.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			1,680,000.00	1,680,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>875,277,100.00</b>	<b>875,277,100.00</b>	<b>999,580,400.00</b>	<b>923,286,302.78</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>875,045,100.00</b>	<b>875,045,100.00</b>	<b>999,580,400.00</b>	<b>923,286,302.78</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	875,045,100.00	875,045,100.00	999,580,400.00	923,286,302.78
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>232,000.00</b>	<b>232,000.00</b>	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	232,000.00	232,000.00	-	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	52	46	52	47
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	34	29	34	23
620003	Үйлчлэх ажилтан	17	16	17	23
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	52	46	52	47
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	48	43	48	45
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	3	4	2

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн тооллого, тооцоо бодолттой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05/41 дугаар албан бичгээр 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Татварын хэлтэс нь тус аймгийн нутаг дэвсгэрт улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх, татварын хууль тогтоомжийг татвар төлөгчдөд сурталчлах, татварын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгын дор үйл ажиллагаа явуулдаг Татварын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгүүлдэг, Сангийн сайдын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Татварын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх 5 арга хэмжээ
- Төсвийн орлогыг бүрдүүлэх 6 арга хэмжээ
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах 16 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж 89,83 хувьтай В үнэлгээтэй дүгнүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Татварын хэлтсийн дотоод аудитын чиг үүрэг, түүний үйл ажиллагааг Татварын газрын Стратеги төлөвлөлт дотоод аудитын газраас хяналт шалгалт хийснийг гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглана гэж шийдвэрлэсэн.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Татварын хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 13.356.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,017.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын суурь үзүүлэлт, материаллаг байдлын түвшин, гүйцэтгэлийн материаллаг байдлын хувийг өөрчлөхгүйгээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлаас 1,5 хувиар буюу 17,001.8 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 12,751.4 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин шинэчлэн тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 2,734.0 мянган төгрөгөөр өссөн байна.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Татварын хэлтэс 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Татварын багц хуулиуд, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,

Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны санхүүгийн байдал, үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн “Emerald” программыг ашиглаж нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байна.

### **Орлого:**

Төв аймгийн Татварын хэлтэс нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 999,580.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 80,065.3 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны орлогыг 1,079,645.7 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд нийт үйл ажиллагааны мөнгөн орлогыг урсгал үйл ажиллагааны санхүүжилт 999,580.4 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

### **Зардал:**

Төв аймгийн Татварын хэлтэс нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 1,133,455.4 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар нийт зардал 999,580.4 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зардал 923,286.3 мянган төгрөг зарцуулж тайлагнасан байна.

### **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:**

Тус байгууллага төрийн сангийн 100140011001 тоот дансанд 2021 онд 999,580.4 мянган төгрөгийн орлого, 999,580.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Нэмэлт санхүүжилтийн дансгүй байна.

### **Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 811,888.8 мянган төгрөг, тайлант онд ТЕГ-аас 46,490.4 мянган төгрөгөөр 20 ширхэг зөөврийн компьютер, аймгийн ЗДТГ-с 5,000.0 мянган төгрөгийн дээвэр, 14,999.5 мянган төгрөгийн сургалтын танхимын 107 ширхэг тавилга үнэ төлбөргүй хүлээн авч, үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 878,378.8 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 98,854.2 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 20,880.3 мянган төгрөг, ТЕГ-аас үнэ төлбөргүй ирсэн 10,974.9 мянган төгрөгийн 21 ширхэг ажлын хослол, 44.0 мянган төгрөгийн үнэт цаас, 2,304.4 мянган төгрөгийн гарын авлага материал хуулийн эмхэтгэл, 21 ширхэг энгэрийн тэмдэг шилжүүлэн авч, нийт 34,455.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, тайлант онд нийт зарцуулсан 30,720.4 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгож, бараа материалын эцсийн үлдэгдэл 102,589.5 мянган төгрөг байна.

**Авлага, өглөгийн талаар:**

Тайлант жилийн авлагын эхний үлдэгдэл 0 төгрөг, нэмэгдсэн 1,666.5 мянган төгрөг, хасагдсан 1,666.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Өглөгийн данс эхний үлдэгдэл 0 төгрөг, нэмэгдсэн 923,286.3 мянган төгрөг, хасагдсан 923,286.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч 22 байгууллагатай тооцооны үлдэгдлийн баримтаар тооцоо нийлж баримтжуулсан байна.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон арилжааны банкны харилцах данс үлдэгдэлгүй байна. Бараа материал 102,589.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 532,616.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	98,854.2	102,589.5	3,735.3
Үндсэн хөрөнгө	590,161.6	532,616.6	-57,545.0
Нийт хөрөнгө	689,015.8	635,206.1	-53,809.7
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	689,015.8	635,206.1	-53,809.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	689,015.8	635,206.1	-53,809.7

Авлагын данс, өглөгийн данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 102,589.5 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 3,735.3 мянган төгрөгөөр өссөн нь ТЕГ-аас 10,974.9 мянган төгрөгийн 21 ширхэг ажлын хослол үнэ төлбөргүй шилжүүлж авсан нь бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 532,616.6 мянган төгрөг болж 57,545.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд ТЕГ-аас 46,490.4 мянган төгрөгөөр 20 ширхэг зөөврийн компьютер, аймгийн ЗДТГ-с 5,000.0 мянган төгрөгийн дээвэр, 14,999.5 мянган төгрөгийн сургалтын танхимын 107 ширхэг тавилга үнэ төлбөргүй хүлээн авсан боловч, тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 124,034.9 мянган төгрөг байгаа нь нөлөөлсөн байна.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн 635,206.1 мянган төгрөг болж, 53,809.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төв аймгийн Татварын хэлтэс нь 2020 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 05/227 тоот албан бичгээр 2021 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 1,092,441.2 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний урсгал зардалд 1,092,441.2 мянган төгрөгөөр төлөвлөж, ТЕГ-ын хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 92,860.8 мянган төгрөгөөр бууруулан улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагын дүнг 999,580.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 999,580.4 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн бүрдүүлж, урсгал үйл ажиллагаандаа 923,286.3 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 76,294.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 923,286.3 мянган төгрөг буюу 92,4 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

3.7.1. Батлагдсан төсвөөс цалин, НДШ, байр ашиглалттай холбогдсон зайлшгүй зардлыг хасаж, хэмнэж болох бусад зардлын 98,689.5 мянган төгрөгийн тодорхойлсон зардлаас ЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хянахад 2,955.9 мянган төгрөгийг хэмнэсэн нь 10 хувьд хүрэхгүй байна.

Байгууллагын даргын 2021 оны 10 дугаар сарын 16-ны А/34, 2021 оны 12 дугаар сарын 17-ны А/43 дугаар тушаалууд гарган хоол, тэмдэглэлийн дэвтэр, үзэг, байцаагчийн үнэмлэхийн гэр, оосор, туг бичиг хэргийн бусад зардлыг зарцуулсан сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 23-нд зохион байгуулж, сумдын байцаагч нарыг цуглуулахад 4,220.0 мянган төгрөгийн албан томилолт, гүйцэтгэлээр нийт 9,800.0 мянган төгрөгийн зайлшгүй биш зардлыг гаргасан байна.

Байгууллагын дарга 2021 оны 01 дүгээр сарын 05-нд 3,500.0 мянган төгрөгийн үнэлгээтэй татварын хэлтсийн танилцуулга цахим хуудсанд ашиглах фото зураг болон видео шторк, анонс бэлтгэх “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж, 2021 оны 6 дугаар сарын 17-нд 1,750.0 мянган төгрөг, 2021 оны 12 дугаар сарын 23-нд 1,750.0 мянган төгрөг шилжүүлсэн байна. Энэхүү байгуулсан гэрээ нь байгууллагын шилэн дансны цахим хуудасны “Бусад” цэсэнд тухайн цаг хугацаанд байршуулаагүй, ажил хийгдэж эхлэх цагаас бүрэн хэрэгжих хүртэлх хугацаанд өглөг авлагын мэдээнд тайлагнаагүй байна.

Дээрх үйл ажиллагаанууд нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “ үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.5-д “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасныг хэрэгжүүлээгүй 13,260.0 мянган төгрөг зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Хүснэгт 2. Улсын төсөвт буцааж, татан төвлөрүүлсэн үлдэгдэл болон хэмнэж болох зардлын тооцоолол

Үзүүлэлт		Төсвийн байдал			/мянган төгрөг/ Хэмнэж татан төвлөрүүлсэн	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	Төсөв	Төвлөрүүлсэн хувь
Засгийн газрын 2021оны 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар:						
<b>2021оны нийт батлагдсан төсвөөс:</b>		999,580.4	923,286.3	92.4%	76,294.1	100.0%
Зайлшгүй шаардлагатай	Цалин, НДШ	775,167.2	702,963.8	90.7%	72,203.4	94.6%
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,388.7	42,254.0	102.7%	1,134.7	1.5%
	Ажил олгогчоос олгох тэтгэмж	82,335.0	82,334.9	99.99%	0.1	
<b>Бусад урсгал зардал</b>		98.689.5	95,733.6	97.0%	<u>2,955.9</u>	3.9%
Хэмнэж болохоор тооцоолсон 10 хувь		<u>9,869.0</u>				

ТЕГ-с цахим хурлаар “...төсөв чинь 20 хувь танагдсан байгаа тул бүрэн зарцуулж болно.” гэж хэлсэн учраас зарцуулсан гэж байгууллагын удирдлага тайлбар өгч байна.

**3.7.2.** Үндсэн хөрөнгийн бусад хөрөнгөд бүртгэлтэй 20,250.0 мянган төгрөгийн үнэтэй 1 ширхэг зуслангийн хашааг байгууллагын нярав Н.Баярмаагийн эзэмшилд тоолсон байна. Төв аймгийн Засаг даргын 2012 оны 9 дүгээр сарын 24-ний А/495 захирамжаар аймгийн төсвийн 2011 оны хэмнэлтээс олгосон урамшууллаар 2012 онд бэлтгэсэн байна. Өнөөдөр тухайн хашаа ашиглалтгүй грашид байгаа гэх боловч, эзэмшил тодорхой биш байна.

Тухайн хөрөнгөнд нарийвчилсан тооллогыг хийх байсан боловч цаг хугацааны хувьд боломжгүй, нягтлан бодогч Р.Мөнхбаярын ирүүлсэн тайлбарт: “Грашид 10-15 ширхэг хашааны хайс, 14 шон хураалттай байгаа. Газар дээр нь ямар ч хашаа байхгүй.” гэсний дагуу дутагдлыг тооцоход, анх худалдаж авсан 270 ширхэг хашааны хайс / 1ширхэг нь тухайн үеийн ханшаар 75.0 мянган төгрөгийн үнэтэй, 2 метр урттай 1.5

метр өндөртэй 810 метр.кв/ зуслангийн хашааны 255 ширхэг нь тоногдож 19,125.0 мянган төгрөгийн хөрөнгө дутаж байна.

Шалгагдагч байгууллагаас: “Тухайн хөрөнгө үндсэн хөрөнгөд бүртгэгдээд 10 жилийн хугацаанд элэгдэл байгуулагдсаар, дансны үлдэгдэл өртөг 1,685.3 мянган төгрөг байна. Актыг хүлээн зөвшөөрөхгүй.” гэж тайлбар өгч байгаа нь төрийн өмчийг үлдэгдэл өртөггүй болохоор данснаас хасаж, үнэгүйдүүлж, зориулалт бусаар хөрөнгө зарцуулагдах эрсдэл агуулагдаж байна.

Төв аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 02 дугаар сарын 21-нд 05/68 тоотоор Төв аймаг дахь Цагдаагийн газарт энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэгдсэн талаар аудитын явцад хандсан байна.

**3.7.3.** Байгууллагын даргын 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн А/24, А/25 дугаар тушаалуудаар Төв аймгийн Татварын хэлтсийн дарга болон Эс Ди Партнерс ХХК-ийн хооронд байгуулсан “Татварын хэлтсийн сургалтын танхимын дээврийн засварын ажил” ТӨАОНӨГ/202009106 Төв дээвэр 2021/08 тоот аймгийн ЗДТГ-аас санхүүжүүлсэн, 19,999.3 мянган төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий ажлыг хүлээж аваад дансанд тусгаагүй байсныг аудитаар илрүүлж, дээврийг 5,000.0 мянган төгрөгөөр, сургалтын танхимд 7 нэр төрлийн 107ш тавилга, гадна дотор 2 вакум хаалга 14,999.5 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

### **3.8 Аудитын гол асуудал**

**3.8.1.** ТӨБЗГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны А-1/1877 тоотоор зөвшөөрөл авч ТЕГ-с Төв аймгийн Татварын хэлтэст 20 иж бүрдэл компьютер ирснийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

Мөн ТЕГ-с 21 иж бүрдэл /пиджак, өмд юбка, цамц, зангиа/ 10,974.9 мянган төгрөгийн ажлын хувцас, 21 ширхэг 252.0 мянган төгрөгийн энгэрийн тэмдэг ирүүлснийг бараа материалын бүртгэлд орлого авсан байна.

**3.8.2.** Дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2021 онд Төв аймгийн Татварын хэлтсийг "ИХ" эрсдэлтэй байгууллагаар дүгнэсэн бөгөөд, илрүүлсэн зөрчлүүд нь 2019, 2020 оны цалин хөлс урамшуулал болон түүнээс суутгах татвар шимтгэлийн зөрүүтэй асуудлууд гарсан бөгөөд тухайн үед нягтлан бодогчоор ажиллаж байсан Л.Баярмаатай холбогдуулан нэхэмжилж Татварын хэлтсээс шүүхэд хандсан байна.

Төв аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 151/ШШ2021/00798 дугаар шийдвэрээр шийдвэрлэгдсэн боловч, хариуцагч дараагийн шатны шүүхэд давж заалдсан байна.

Энэ асуудал нь Татварын улсын байцаагчийн /ТЗ/ цалингаар төлөвлөгдөж ирсэн цалингийн зардлаас татвар хураагч /ТҮ/ нар цалинжуулж, их хэмжээний цалингийн зардлын төсвийн хэмнэлтийг дур мэдэн зарцуулдаг асуудалтай холбоотой байж болох тул Цалин хөлс, кассын орлогыг эрсдэл үүсэж болзошгүй ажил гүйлгээний ангиар тодорхойлж гол асуудал болон дараагийн аудитаар анхаарах асуудлаар тодорхойлж байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулахаас 136 мэдээлэл байршуулж, 7 мэдээлэл хугацаа хоцроож, 3 мэдээлэл огт байршуулаагүй 91,9 хувьтай хэрэгжүүлсэн байна. Хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Аймгийн ЗДТГ-аас санхүүжүүлсэн сургалтын танхимын дээврийн засварын ажил, тавилга нийлүүлсэн худалдан авалтын материал болон дутагдаж байгаа хашааны хайсны талаар тайлбар ирүүлэх асуудалд нярав Н.Баярмаа, нягтлан бодогч Р.Мөнхбаяр нараас нотолгоо олж авах боломжгүй байдал үүсэж, аймгийн ОНӨГ-с зарим лавлагаа мэдээллийг гаргуулж авсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” зарчмуудыг хангаж, холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар шүүхийн шийдвэрээр 1,514.0 мянган төгрөгийн нөхөн олговор олгосныг буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй 1 зөрчилд албан шаардлага хүргүүлснийг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр бүрэн төлж хэрэгжүүлсэн бөгөөд, байгууллагын тооллогын комисс тооллогын бүртгэл үйлдэж, нягтлан бодогч тооцоо бодсон актаар баримтжуулаагүй, шатахууны зардлыг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах, үндсэн хөрөнгийг капиталжуулах, төсөвт байгууллагад хүлээн зөвшөөрөгдсөн программаар нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, орон тоо, хүний нөөцийг зөв хуваарилж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй 5 зөрчилд зөвлөмж өгснийг Төв аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн №05/153 тоот албан бичгээр төрийн аудитын газарт хэрэгжилтийг гаргаж ирүүлэн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Татварын хэлтсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарах асуудлуудыг тодорхойлж байна. Үүнд:

- Жолоочийн замын хуудсыг үндэслэн шатахууны зарцуулалтын тооцоог тухай бүр бодож баталгаажуулсан байдал
- Үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, дутагдуулсан зуслангийн хашааг хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлсэн байдал
- Дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2021 онд Татварын хэлтсийг "ИХ" эрсдэлтэй байгууллагаар дүгнэсэн бөгөөд, илрүүлсэн зөрчлүүд нь 2019, 2020 оны цалин хөлс урамшуулал болон түүнээс суутгах татвар шимтгэлийн зөрүүтэй асуудлууд тухайн үед нягтлан бодогчоор ажиллаж байсан Л.Баярмаатай холбоотой гарсныг нэхэмжилж шүүхэд хандаж, Төв аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 151/ШШ2021/00798 дугаар шийдвэр гарсан байна. Цалин хөлсний зардал болон кассд орлого авсан бэлэн мөнгөний зарцуулалтын байдал

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 128,924.8 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 96,293.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 256.2 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 32,375.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, үнийн дүнгүй 2 зөрчилд зөвлөмж өгөв.

##### 4.1 Залруулсан алдаа

**4.1.1.** Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 76,294.1 мянган төгрөгөөр тохируулга хийгээгүй алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

**4.1.2.** Аймгийн ЗДТГ-аас санхүүжүүлсэн, 19,999.3 мянган төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий дээврийг 5,000.0 мянган төгрөгөөр, сургалтын танхимд 7 нэр төрлийн 107ш тавилга, гадна дотор 2 вакуум хаалга 14,999.5 мянган төгрөгийн, нийт 19,999.5 мянган төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” заалтуудтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “нийцсэн байх”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

## 4.2 Төлбөрийн акт

**4.2.1.** Төсвийг үр ашиггүй зарцуулж, 256.2 мянган төгрөгийн нийгмийн даатгалд төлөх алдангийг төсвөөс төлсөн зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, заалтыг хэрэгжүүлээгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “нийцсэн байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

## 4.3 Албан шаардлага

**4.3.1.** Байгууллагын даргын 2021 оны 10 дугаар сарын 16-ны А/34, 2021 оны 12 дугаар сарын 17-ны А/43 дугаар тушаалууд гарган хоол, тэмдэглэлийн дэвтэр, үзэг, байцаагчийн үнэмлэхийн гэр, оосор, туг бичиг хэргийн бусад зардлыг зарцуулсан сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 23-нд зохион байгуулж, сумдын байцаагч нарыг цуглуулж 4,220.0 мянган төгрөгийн албан томилолтыг зарцуулсан, мөн байгууллагын дарга 2021 оны 01 дүгээр сарын 05-нд 3,500.0 мянган төгрөгийн үнэлгээтэй татварын хэлтсийн танилцуулга цахим хуудсанд ашиглах фото зураг болон видео шторк, аннос бэлтгэхээр “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж /энэхүү гэрээг байгууллагын шилэн дансны цахим хуудасны “Бусад” цэсэнд тухайн цаг хугацаанд байршуулаагүй, ажил хийгдэж эхлэх цагаас бүрэн хэрэгжих хүртэлх хугацаанд өглөг авлагын мэдээнд тайлагнаагүй/ нийт 13,260.0 мянган төгрөгийн зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, Засгийн газрын 2021 оны

2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.5-д “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасныг хэрэгжүүлээгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “нийцсэн байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” бол албан шаардлага өгөх гэсний дагуу шийдвэрлэв.

**4.3.2.** Нягтлан бодох бүртгэлийн программаас санхүүгийн тайлан, журналууд хагас дутуу татагдсан, тайлан хугацаа хоцорч 2022 оны 01 дүгээр сарын 31-нд ирсэн. Сангийн яамны шаардлагыг хангаагүй, төсөвт байгууллагад хөтлөгдөх зөвшөөрөлгүй программаар бүртгэлийг хөтөлж байгаа нь өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалт хэрэгжээгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “ аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй” бол албан шаардлага өгөх гэсний дагуу шийдвэрлэв.

**4.3.3.** Бусад үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 20.2 сая төгрөгийн үнэ бүхий зуслангийн хашаа тоногдож, грашид 15 ш хайс байгаа бөгөөд 19,125.0 мянган төгрөгийн үнэ бүхий 255 ширхэг хайс шон дутаж байна.

Энэ нь ТБОНӨТХ-ийн 67 дугаар зүйлийн 67.2-д “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.”, 70 дугаар зүйлийн 70.2-д “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”, 73 дугаар зүйлийн 73.2-д “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв

байх”, 13 дугаар зүйлийн 13.6-д “ анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” заалтуудтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “нийцсэн байх”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.3-д “ өмч хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан.” бол албан шаардлага өгөх гэсний дагуу шийдвэрлэв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **4.4.1.Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Сүүлийн 2 жил дараалан үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч аваагүй алдааг давтан гаргаж байгаа зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” заалтуудтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “нийцсэн байх”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгийг санхүүжилтийн эх үүсвэрийг харгалзахгүйгээр тухай бүр нь орлого авч байх

##### **4.4.2.Нийцлийн аудитын асуудал**

###### **1.2. Илрүүлэлт:**

Тус байгууллага нь шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хуулийн хугацаанд нь 136 мэдээлэл байршуулж, 7 мэдээлэл хугацаа хоцроож, 3 мэдээлэл огт байршуулаагүй 91,9 хувьтай хэрэгжүүлсэн байна. Байршуулсан мэдээлэлүүд үнэн зөв, бодитой, ач холбогдолтой биш, PDF файлаар оруулаагүй байгаа зэрэг зөрчил байна. Энэ нь санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" зарчмууд хангагдахгүй байна

###### **Өгсөн зөвлөмж:**

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандарт тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс:							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Татварын хэлтэс	8	128,924.8	2	96,293.6	1	256.2	3	32,375.0	2	0